

Ядуусын төлөөх хөгжил гэж юу вэ?

Үүнийг хийж болох уу?

Үүний тулд юу хийж болох вэ?

Ц.Болд, МУИС-ийн ЭЗС-ийн татвар, 3 курс, оюутан

Хөгжил гэдэг бол амьдралын дэвшил. Тиймээс хөгжлийг бүгд л хүсдэг. Хар даран зүүдэлж буй хүн нааш цааш хөрвөөж, нүүр нь үрчлээтсээр яаж сэрэхээ мэдэхгүй, эцэстээ орилон босож ирдэг. Тиймээ, үүнтэй нэгэн адил ядуурал ард түмнийг нөмрөн авч, түүнээс яаж гарахаа тэд ойлгохгүй, чадахгүй, эцэстээ нийгэм самуунд өртдөг. Ядуу төрсөн нь тэдний ялагдал биш, ядууралд өртөөд түүнээс ангижирч чадвал тэдний ялалт байх болно.

«Impossible is nothing» буюу «Боломжгүй гэдэг бол юу ч биш». Энэ үг Солонгосын ард түмний уриа. Тэд үргэлж өнөөдрийнх шигээ өндөр хөгжилтэй, баян ард түмэн байгаагүй юм. Солонгос дэлхийн II дайны дараа өнөөдрийн Монголтой адил хөгжил дорой, ядуу байсан. Бүх зүйл өөрчлөгддөг. Өөрчлөлт сайнчталтай, муучталтай. Гагцхүү бидэнд сайн зүйлд хүргэх өөрчлөлт туйлын чухал бөгөөд сайтар тунгаавал үүнээс илүү зүйл үгүй, Тиймээс бид өөрчлөлтийг хийж, хөгжил рүү тэмүүлж, үр дүнд хүрч чадна. Бид чухам аль хаалгыг онгойлгох, хаалганы цаана юу байж болох талаар төсөөлөл авлаа. Харин одоо бидэнд юу хэрэгтэй, бид юу хийх хэрэгтэй вэ. Тиймээ, танд олон түлхүүр байна, гол нь та тэр түлхүүрүүдээс хаалгыг онгойлгох зөв түлхүүрийг хурдан хугацаанд олох шаардлага тулгарна шүү дээ. Та арай хаалгыг өөрөө онгойно гэж бодоогүй биз дээ?.

Эдийн засгийн өсөлт ч чухал, ядуурлыг бууруулах асуудал ч чухал. Ядуурал эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөөтэй бөгөөд эдийн засгийн өсөлт бүр ядуурлыг бууруулах

үндэс болж чадахгүй. Ажил эрхлэлтийг бий болгодог өсөлт хэрэгтэй ба ажилчдыг өөртөө шингээх хувийн сектор юунаас ч чухал. Ямар ч атугай Монголд хүн амын 20-40 хувь нь ядууралд өртөж байгаа ба асар олон тооны хүмүүс ядуурлын ирмэгт тулж, ядуурлын шугамд ялимгүй өөрчлөлт орлоо л бол албан ёсны тодорхойлолтын заагт дөхөж очоод байна. Ядуурлын мэдрэмжинд анхаарлаа хандуулъя.

Хүмүүн капиталын гурван онол бий:

- Адам Смит: хүн хөдөлмөрлөх хэрэгтэй
- Кейнс: хүн боловсролтой байх хэрэгтэй
- Окона: хүн чадавхитай байх хэрэгтэй.

Эдгээр нь дангаараа учир дутагдалтай зүйлүүд. Хүн орлого, үр ашиг багатай ажилд хөдөлмөрлөөд байвал, мөн хичнээн боловсролтой байгаад эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж чадахгүй байвал, чадавхитай байлаа ч түүнийгээ ашиглах чадваргүй байвал яах вэ?. Энэ бүхэн өнөөдрийн Монголын нийгэмд тодорхой байгаа зүйл. Тиймээс нэг нь нөгөөгөө дэмжиж хөгжүүлдэг элементүүдийн нэгдэл үр дүнтэй.

Хувь хүнд байдаг гурван капитал нь оюун ухаан, эрүүл мэнд, цаг хугацаа юм. Тиймээс хувь хүнд боломж олгоё, хувь хүнийг дэмжье, хувь хүнийг чадвартай болгоё. Иргэн баян бол улс баян гэдэг шүү дээ.